



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 0/224

Улаанбаатар хот

**Багахангай дүүргийн Хангай цогцолбор
сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 21,059,794.0 /хорин нэгэн сая тавин есөн мянга долоон зуун ерэн дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургууль /А.Сүхболд/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургууль /А.Сүхболд/-д үүрэг болгосугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 07 сарын
08 өдрийн 0/22.4 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургууль

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХК-ын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	5-19	ш	4573		21,059,794.0	0.0	21,059,794.0	ашиглагдахгүй	устгах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						21,059,794.0	0.0	21,059,794.0		
Үүнээс: Худалдах хөрөнгө						0.0	0.0	0.0		
Актлах хөрөнгө						21,059,794.0		21,059,794.0		
Татан төвлөрүүлэх хөрөнгө						0.0	0.0	0.0		
Худалдсанаас олох орлого						0.0	0.0	0.0		
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						0.0	0.0	0.0		